



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 11 дүгээр сарын 07 өдөр

Дугаар 90

Хэрлэн сум

LXXXX ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 90 дүгээр хуралдаан 2021 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 10:00 цагт танхимаар 80,0 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Хуулийн этгээд аймгийн Онцгой комиссоос байгуулах “Хариуцлагын гэрээ”-ний төсөл танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

2.Хэрлэн сумын дархлаажуулалт, шинжилгээний цэгийг нүүлгэн шилжүүлэх асуудлын талаар хэлэлцэх,

Эрүүл мэндийн газар

3.Аймгийн Засаг дарга, Онцгой комиссын даргаар ахлуулсан ажлын хэсэг сумдад ажилласан талаар мэдээлэл танилцуулах,

Аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа нарт:



1.1.Байгууллагуудтай аймгийн Онцгой комиссоос байгуулах “Хариуцлагын гэрээ”-ний төсөлд гишүүдийн саналыг тусгаж батлуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,

Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Д.Мөнхтуяа,

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч, Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир нарт:

1.2.Урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулахад хариуцлагын гэрээ байгуулах талаар заал, танхимтай Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар,

 / М.Бадамсүрэн
 /х/а Г.Нармандах

Хөгжимт драмын театр, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, Политехник коллеж, "ДБЭХС" ТӨХК, Ерөнхий боловсролын сургуулийн удирдлагуудтай уулзалт зохион байгуулж хариуцлагын гэрээг байгуулах,

1.3. Урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулахад хариуцлагын гэрээ байгуулж ажиллах талаар сумын Онцгой комисстой цахим хурал зохион байгуулж танилцуулах,

Хоёр. Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

2.1. Дархлаажуулалтын нэмэлт 3 дугаар тунгийн ач холбогдлын талаар зөвлөмжийг олон нийтэд сурталчлах,

2.2. Дархлаажуулалтын цэгийг Нийгмийн эрүүл мэндийн төвд, Шинжилгээний цэгийг Зооноз өвчин судлалын төвийн байранд шилжүүлж ажиллуулах,

АЗДТГ-ын Олон нийттэй харилцах хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Э.Батболд-д:

2.3. Дархлаажуулалт, шинжилгээний цэгүүдийг шилжүүлсэнтэй холбогдуулан олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулахыг тус тус үүрэг болгов.

ДАРГА

М.БАДАМСҮРЭН

ОРЛОГЧ ДАРГА,
ХУРАНДАА

Г.НАРМАНДАХ

